

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ДУНДГОВЬ АЙМГИЙН *Дорж*
СҮМҮН ЗАСАИ ДАРГА
Дорж
(Гарын үсэг)
ТУ31450 №033364

ГҮЙЦЭТГЭГЧ:

“ХААИС” МАЛ АЖ АХУЙ,
БИОТЕХНОЛОГИИ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Д.ГҮРБАЗАР
(Гарын үсэг)
9021110374
ТУ32800 № 90299395

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2023.01.25.

№ 010.

Г.Зандагийн Энэхүү гэрээг нэг талаас Дундговь аймгийн сумыг төлөөлж (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 22-р хороо ХААИС, Мал аж ахуйн сургуулийн багш Т.Ариунболд (цаашид “зөвлөх” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 01 дугаар сарын 25-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) бид Монгол Улсын Иргэний хуулийн 399-405 дугаар зүйл болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журмыг удирдлага болгон дараах нөхцөлийг харилцан тохиролцон байгуулав. байгуулав.

Ажлын нэр: “Мал, амьтны үржлийн ажлын стратеги боловсруулах”

1. НИЙТЛЭГ ЗААЛТ

1.1. Энэхүү гэрээгээр гүйцэтгэгч нь уг гэрээний Хавсралт 1-д заасан ажлын даалгаврын хүснэгтэд тусгасан ажлуудыг гэрээнд заасан хугацаанд, чанаарын өндөр түвшинд, уг гэрээний дагуу хийж гүйцэтгэн захиалагч талд шилжүүлэх, ажлын гүйцэтгэлийн талаар захиалагчийн эрх бүхий албан тушаалтанд тайлагнах, нөгөө талаас захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрийг төлөх, талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээнд зохицуулагдаагүй харилцааг Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.

2. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1. Энэхүү Гэрээ нь 2023 оны 01 дугаар сарын 25-ний өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 25-ний өдрийг дуустал 120 хоногийн хугацаатай байна.

2.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас ажил гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадахгүйд хүрвэл захиалагчид нэн даруй мэдэгдэж захиалагч нь нэмэлт хугацаа тогтоож өгнө.

3. АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

3.1. Гэрээгээр тохиролцсон хууль зүйн үйлдлийг /ажил/ хийсний төлбөрт нийт 2 000 000 (хоёр сая) төгрөгийн төлбөр олгоно. Энэ дүнд зөвлөхийн бүх зардал, ашиг, мөн түүнчлэн зөвлөхөд ногдож болох аливаа татвар, хураамж орсон болно. Төлбөрийг ХААН банкны 5070050804 тоот дансанд шилжүүлнэ.

3.2. Гэрээний үнийн дүнгийн 50.0 хувьтай тэнцэх дүнг гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан гүйцэтгэгч талд шилжүүлнэ.

3.3. Даалгаврын гэрээний ажлыг хугацаанд нь бүрэн гүйцэтгэж, тайланг хүлээлгэн өгсний дараа гэрээг дүгнэж үлдэгдэл 50.0 хувийг ажлын 5 хоногт багтаан олгоно.

4. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Гүйцэтгэгч нь ХААИС, МААБС-ийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулна.

4.2. Гүйцэтгэгч нь даалгаврыг гүйцэтгэхдээ итгэмжлэгчийн өгсөн зааврын дагуу гүйцэтгэх үүрэгтэй.

4.3. Захиалагчийн ашиг сонирхлын үүднээс түүний өгсөн зааврыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ талаар урьдчилан мэдэгдэх боломжгүй байсан, эсхүл мэдэгдсэн боловч хугацаандаа хариу аваагүй бол гүйцэтгэгч нь уг зааврыг өөрчлөх эрхтэй.

4.4. Гүйцэтгэгч нь захиалагчийн шаардлагаар гүйцэтгэж байгаа ажлын явцын талаар мэдээлэх үүрэгтэй.

4.1. Гэрээгээр тохирсон төлбөр, даалгавар гүйцэтгэхд гарах зайлшгүй зардал, гэрээний үүргийг биелүүлэхтэй холбоотой мэдээ, материал, бусад баримтыг итгэмжлэгчээс шаардах эрхтэй.

4.2. Гүйцэтгэгч нь захиалагч талаас авсан албан мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй.

4.3. Шаардлагатай тохиолдолд даалгавар биелүүлэх ажиллагаанд захиалагчийг оролцуулна.

5. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1. Захиалагч нь өгсөн даалгаврынхаа гүйцэтгэлийг хугацаанд нь хүлээн авах, даалгавар гүйцэтгэхтэй холбогдох өөрөөс хамааралтай мэдээ, материал, бусад баримт, зардлыг гүйцэтгэгчид хугацаанд нь өгөх үүрэгтэй.

5.2. Гэрээнд заасан төлбөрийг гэрээний хугацаанд нь төлөх үүрэгтэй.

5.3. Гүйцэтгэгчийн явуулж байгаа үйл ажиллагаатай танилцах, зааварчилгаа өгөх, өөрчлөх эрхтэй.

5.4. Гүйцэтгэгчийн явуулж байгаа үйл ажиллагаанд даалгавар өгөгч биечлэн оролцох шаардлагатай тохиолдолд өөрөө биечлэн эсвэл боломжгүй үед өөрийн Төлөөлөгчийг оролцуулна.

6. БУСАД ЗААЛТ

6.1. Энэ гэрээ талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээг дүгнэх хүргэл (даалгавар биелүүлэх, талуудын тооцоо хийх) бүх хугацааны турш үйлчилнэ.

6.2. Гэрээг 2 хувь үйлдэж талууд нэг нэг хувийг хадгална.

6.3. Итгэмжлэгч өгсөн даалгавраа цуцалсан, итгэмжлэгдэгч нь даалгавар биелүүлэхээс татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд Иргэний хуулийн 402-р зүйлд зааснаар нэг тал нөгөө талдаа учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.

6.4. Итгэмжлэгч энэхүү даалгаврын гэрээний дөрөвт заасан үүргийг биелүүлээгүй буюу дутуу, чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд тухайн ажлыг нөхөн хийхэд шаардагдах хэмжээгээр хариуцлага хүлээх ба түүнийг ажлын хөлснөөс суутган тооцно.

6.5. Хэрэв талуудын хооронд маргаан гарвàл талууд эвийн журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг баримтална.

7. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Дундговь аймгийн Дэргэн сумыг
төлөөлж.....ХДТЛ.....99/20

Бүсэд
~~(Гарын үсэг)~~

ГҮЙЦЭТЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХААИС, Мал аж ахуй биотехнологийн
сургуулийн багш Т.Ариунболд

Нийгээ
~~(Гарын үсэг)~~